

**ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Огноо: 2024 оны 3 сарын 23-ны өдөр

Цаг: 10:00

Хэлбэр: Танхим

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;
2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах;
3. “Ногдол ашиг хуваарилах тухай” ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах;
4. Хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргах тухай хэлэлцэн батлах
5. Хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргахтай холбогдуулан Тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэх эсэхийг хэлэлцэн батлах
6. Компанийн зарласан хувьцааны тоог нэмэх тухай хэлэлцэн батлах
7. Компанийн шинэчилсэн дүрэм батлах
8. Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн батлах
9. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсөв батлах;
10. Бусад

Тооллогын комиссын дарга М.Уянга хурлын ирц танилцууллаа.

Хурлын ирц: 79.77%

Хурлын дарга Ч.Чинзориг: Сайн байцгаана уу. Хувьцаа эзэмшигчдийн хуралд ирсэн та бүхэнд баярлалаа. Тандэм инвэст ББСБ ХК-ийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нээснийг үүгээр мэдэгдэж байна. Хурлын ирц 79.77 хувьтай байна. Энэ хуралд оролцох байсан гадаадын нэг хувьцаа эзэмшигч маань итгэмжлэлээ ирүүлж амжсангүй гэдгээ мэйлээр мэдэгдсэн байгаа. Хурлаар хэлэлцэх асуудлууд та бүхэнд тараагдсан материалд байгаа. Хурлын дэгийн дагуу тооллогын комиссын дарга та бүхэнд ирцээ танилцууллаа.

Ингээд хурлын дэгийг танилцуулъя.

Дд	Хурлын дэг	Хугацаа
1	Хурлын ирц бүртгэх /тооллогын комисс/	09:50-10:00 цаг
2	Хурлын дарга хурлын ажиллагааг нээж, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулах /хурлын дарга/	5 минут
3	Хэлэлцэх асуудлыг дарааллын дагуу хэлэлцүүлэх /хурлын дарга/	Асуудал тус бүр дээр 5 хүртэл минут хэлэлцүүлэх
4	Компанийн дүрмийн өөрчлөлтийг танилцуулах /гүйцэтгэх захирал/	5 минут

5	Хуралд оролцогсдын асуулт хариулт, санал, дүгнэлт авах	Хүн тус бүрээр 1-2 минут
6	Саналын хуудсаар санал авах /тооллогын комисс/	10 минут
7	Санал хураалтын дүнг нэгтгэх /тооллогын комисс/	30 минут

Та бүхэнд хурлын дэгийг танилцууллаа.

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг гүйцэтгэх захирал Ганхүлэгийг танилцуулахыг урьж байна.

Гүйцэтгэх захирал Ж.Ганхүлэг: Сайн байна уу? Та бүхэндээ энэ өглөөний мэнд дэвшүүлье. Та бүхэндээ 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн мэдээлэл хүргэе.

Компанийн тухай

			
Дүрмийн сан	Зөвшөөрөл	Бүтээгдэхүүн	Зардал
3,468,668,428	3	9	2,338,847,224
			
Хувьцааны тоо	Зээлийн багц	Итгэлцэл	Ажилчид
1,508,116,708	19,572,396,824	4,957,963,733	9
Зээлийн багц ➢ Автомашин - 84.9% ➢ Үхэндэг хөрөнгө багцмажсан - 0.6% ➢ Орон сууцна хэргийн алах - 2.4%		Итгэлцэл 2021 онд 10 харилцагчийн 1 тэрбум төгрөг 2022 онд 5 харилцагчийн 3,7 тэрбум төгрөг татсан. 2023 онд 6 харилцагчийн 2.3 тэрбум төгрөг татсан.	
➢ ЖЭЛХ Хөрөнгө оруулалт - 0.8% ➢ Шугам - 5.2% ➢ Азүй хөрөнгө - 0.1%			

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

ШИЙДВЭР ТОГТООЛ

- 2022 онд санхүүгийн тайлан түүнд хийгдсэн аудитын дүгнэлтийг батлах тухай
- ТУЗ-ийн гишүүд сонгох тухай
- Хаалттай хүрээнд бонд гаргах тухай
- Нээлттэй болон хаалттай хүрээнд ХБҮЦ гаргах тухай
- 2023 оны ТУЗ-ийн төсөв батлах тухай

ХУРЛЫН ТОО -1



Санхүүгийн гол үзүүлэлтүүд

НИЙТ ХОРОНГО 16.7%↑

ӨӨРИЙН ХӨРӨНГӨ 9.2% ↑

ХҮҮНИЙ ОРЛОГО 78.6%↑

ЦЭВЭР АШИГ 65.6%↑



ХАРЬЦУУЛАЛТ

Банк бусын салбар	Үзүүлэлт	Тандэм Инвэст ББСБ ХК
34.1%	Нийт орлогын өсөлт	70.8%
38.1%	Цэвэр ашгийн өсөлт	65.7%
3.3%	Зээлийн хүү	2.7%
71%	Итгэлцлийн үйлчилгээ	43.1%
7%	NPL	6.5%

Хурлын дарга Ч.Чинзориг:

За Ганхүлэг захиралдаа баярлалаа. “Шинэ их тэр бум” гээд аудитын компаниас төлөөлөн Оюунтуяа гээд хүн ирсэн байгаа. Та бүхэн аудитын тайлантай холбоотой асуулж тодруулах зүйл байвал асуулт хариулт дээр тодруулаарай. За ингээд компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дарга Энх-Амгалан танилцуулна.

Б.Энх-Амгалан: Тайлант хугацаанд Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хорооноос компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь хууль тогтоомж, компанийн дүрэм, хувь нийлүүлэгчдийн хурлаас олгогдсон эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэх, мөн компанийн санхүүгийн үйл ажиллагаанд дэд хорооны эрх үүргийн хүрээнд хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгон хяналт тавьж ажиллалаа. Тандэм Инвэст ББСБ ХК-ийн жилийн эцсийн санхүүгийн тайланд 2020 оноос эхлэн СЗХ-нд бүртгэлтэй Шинэ Их Тэрбум Аудит ХХК

хөндлөнгийн аудит хийн ажиллаж байна. Компанийн хувьд 2023 онд 5,451.1 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан нь өмнөх онтой харьцуулахад абсолют утгаараа 2,399.2 сая төгрөгөөр илүү буюу 78.6 хувиар өссөн дүнтэй гарчээ.

2023 онд хуримтлагдсан цэвэр ашиг 3,303.4 сая төгрөг байсан ба өмнөх онтой харьцуулахад 65,7 хувиар өссөн байна.

Тайлант хугацаанд гарсан үйл ажиллагааны зардлыг ангилж үзвэл:

Цалин	262.6 сая төгрөг
Аудит, мэргэжлийн үйлчилгээ-	4.8 сая төгрөг
Түрээс-	17.0 сая төгрөг
Нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгал-	28.6 сая төгрөг
Маркетинг сурталчилгаа -	36.5 сая төгрөг
Зохицуулалтын хураамж-	91.7 сая төгрөг
Зээл барагдуулахтай холбоотой зардал-	1.2 сая төгрөг
Албан томилолт	43.2 сая төгрөг
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	651.7 сая төгрөг
Хуулийн зөвлөгөө өмгөөлөл	13.0 сая төгрөг

Авлага, өглөгийн тухайд тайлант хугацаанд бусдаас авсан урт хугацааны өр төлбөргүй богино хугацааны өр төлбөр 4,957.6 сая төгрөг. Татварын өглөг 270.9 сая төгрөг байна.

Эздийн өмч ба өр төлбөрийн дүнд богино хугацаат өр төлбөр 26.1 хувийг эзэлж байгаа бол урт хугацааны өр төлбөргүй байна. Эздийн өмч ба өр төлбөрийн нийт дүнд эздийн өмчийн эзлэх дүн 73.9 хувьтай байна.

Эргэлтийн болон Үндсэн хөрөнгийн тухайд 2023 оны эцсийн байдлаар үндсэн хөрөнгийн хэмжээ 443.1 сая төгрөг болсон бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуулахад 8,9 хувиар буурсан дүн юм.

Компанийн зах зээлд зээлийн үйл ажиллагаа явуулж байгаатай нягт холбоотойгоор нийт хөрөнгөд эзлэх эргэлтийн хөрөнгийн хувь 97.9 байна. Өөрөөр хэлбэл компанийн хувьд үндсэн хөрөнгө нь нийт хөрөнгөд маш бага хувь эзэлдэг байна.

Нягтлан бодох бүртгэл ба тайлагнал:

Компанийн 2023 оны санхүүгийн болон удирдлагын үйл ажиллагааг санхүүгийн тайлан, анхан шатны баримт, холбогдох бусад баримт, тайлантай тулган хянахад Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль мөн компанийн тухай хууль болон холбогдох журам зааврын дагуу бүртгэлээ хөтөлж, санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд тайлагнаж харьяа санхүүгийн болон татварын байгууллагад тушаасан байна.

Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-өөс өмч хөрөнгийн ашиглалт зарцуулалт, компанийн удирдлага, албан тушаалтнуудын явуулж байгаа бодлого, үйл ажиллагааны талаар санал гомдол, хүсэлт ирээгүй болно.

Хараат бус аудиторын тайлангаас гаргасан дүгнэлтээр ББСБ-ын санхүүгийн тайлангууд нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн гэж дүгнэгдсэн.

Хурлын дарга Ч.Чинзориг: За баярлалаа. Дараагийн асуудал маань Ногдол ашиг хуваарилах асуудал байгаа. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай компанийн ТУЗ нь 2024.02.09 –ний өдөр хуралдаж цэвэр ашгаасаа 3,3 тэрбум төгрөгийн ногдол ашгийг ХЭ-д хуваарилахаар, бүртгэлийн өдрийг 2024.03.04 –ний өдрөөр тогтоосон байгаа. Компани жилээс жилд ногдол ашгаа тодорхой хэмжээнд өсгөөд хувьцаа эзэмшигчдэдээ үйл ажиллагааныхаа үр дүн, өгөөжийг хүртээж байгаадаа баяртай байгаа. Маркет мн-ий Ганбод гээд манай хувьцаа эзэмшигч залуу ирсэн байна. Бидний ажлын сайн сурталчилж өгдөг залуу байгаа. Өмнө нь танхимаар хуралдахад Ганболд ирж байсан. Тэр үед бид 119 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилж байсан бол 4 жилийн дараа 3,3 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилах хэмжээнд ажилласан байна. Дараа дараагийн жилүүдэд дахин нэмэгдүүлэхээр ажлаа явуулна.

Дараагийн асуудал маань стратегийн хөрөнгө оруулагчид эзэмшүүлэхээр хаалттай хүрээнд нэмж үнэт цаас гаргах асуудал байгаа. Компани 2 тэрбум зарласан хувьцаанаас гаргаагүй үлдсэн 24.59% буюу 491,883,292 ширхэг хувьцааг 26 долоо хоногийн жигнэсэн дундаж ханш 19.79 төгрөг байсан бөгөөд стратегийн хөрөнгө оруулагчид 19.60 төгрөгөөр санал болгосон байгаа. Уг стратегийн хөрөнгө оруулагч маань сүүлийн 4 жилийн хугацаанд 400 сая иений хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд ногдол ашгаа итгэлцлээр компанидаа байршуулдаг Шинтани Такаёши гэж хүн байдаг. Япондоо 30 гаруй эмнэлэг, 80 гаруй сувилал, 5 сургууль, 5 гольф клуб гээд маш том бизнесийн группийг ахалдаг ийм хүн байдаг бөгөөд хөрөнгө оруулалтыг найдвартай хийдэг стратегийн хөрөнгө оруулагчдаа хувьцаагаа санал болгосон байгаа.

Дараагийн асуудал маань компанийн зарласан хувьцааг нэмэгдүүлэх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж байгаа. Одоогийн байдлаар компанийн зарласан энгийн хувьцаа 2 тэрбум байгаа үүнээс 1.5 тэрбум орчмыг гаргасан байгаа, үлдсэн хувьцаагаа стратегийн хөрөнгө оруулагчид санал болгосон байгаа. Тиймээс ТУЗ-ийн зүгээс энгийн хувьцаагаа 3 тэрбумаар нэмэгдүүлэх санал оруулсан байгаа. Компани хөрөнгийн биржийн 2-р цонхонд бүртгэлтэй байгаа бөгөөд 1-р цонхонд орох шаардлагыг хангахад 2 шаардлагыг биелүүлэх шаардлагатай байгаа. 1-рт 20 хүртэлх хувиа эргэлтэд оруулах, хувьцааны тархалтыг нэмэгдүүлэх шаардлага тавьж байгаа. ТУЗ-ийн зүгээс цаашид хоёрдогч зах зээл дээр хувьцаагаа олон нийтэд гаргахаар төлөвлөж байгаа.

Дараагийн асуудал нь зарласан хувьцааны тоо нэмэгдүүлж байгаатай холбогдуулан компанийн дүрэмд өөрчлөлт орох бөгөөд компанийн шинэчилсэн дүрмийг батлуулах байгаа.

Дараагийн асуудал нь 2024 оны бизнес төлөвлөгөөг танилцуулан батлуулах байгаа. Түүрүүн ТУЗ-ийн аудитын хорооны дарга Энх-Амгалангийн танилцуулсан 2023 оны 12-р сарын байдлаарх татварын 270.9 сая төгрөгийн өрийг он гараад буюу 1-р

улиралдаа багтаад бид улсдаа төлчихсөн одоо ямар нэг өргүй байгаа. Та бүхэнд тараагдсан хурлын материалд 2024 оны бизнес төлөвлөгөөг оруулсан байгаа.

	2023 он	2024 он
Нийт хөрөнгө	21,040,839,442	35,907,354,451
Нийт Өглөг	5,471,305,393	8,322,230,297
Нийт эздийн өмч	15,569,534,049	27,585,124,154
Хүүгийн орлого	5,451,099,992	10,000,000,000
Хүүгийн бус зардал	1,250,680,306	3,300,000,000
Цэвэр ашиг	3,303,434,505	5,700,000,000

	2023 он	2024 он
Боловсон хүчний зардал	262,567,561	450,000,000
Түрээс болон үндсэн хөрөнгө	65,774,513	85,000,000
Зохицуулалтын үйлчилгээ болон үнэт цаас гаргахтай холбоотой зардал	104,356,046	*400,000,000
Хангамжийн зардал	20,252,478	210,000,000
Үндсэн бус үйл ажиллагааны зардал/Хөрөнгө оруулалтын зардал	109,828,922	250,000,000
Зээлийн эрсдэлийн зардал	659,876,952	300,000,000
Зээл барагдуулах болон Итгэлцлийн үйлчилгээтэй холбоотой зардал	652,977,663	1,150,000,000
Маркетингийн зардал	36,500,000	100,000,000
Арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зардал	478,990	200,000,000
Бусад	39,286,015	40,000,000
Татварын зардал	373,948,085	700,000,000
Хуулийн зөвлөгөө, өмгөөлөл	13,000,000	26,000,000
Нийт	2,338,847,224	3,911,000,000

Богино болон дунд хугацааны хөрөнгө оруулалт болон санхүүжилтийг нэмэгдүүлэх бодолтой байгаа. Энэ нь өөрийн хөрөнгө буюу бидний хөрөнгө өсч байгаатай холбоотой зах дээрээс итгэлцэл, хаалттай буюу нээлттэй хүрээнд 2 үе шатлалтай 12 тэрбум төгрөгийн бонд, мөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах гэх мэт бид зах зээл дээрээс 30 орчим тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэх нөөц бололцоо байгаа.

Сүүлийн хэлэлцэх асуудал маань ТУЗ-ийн 2024 оны төсөв батлах тухай байна.

№	Зардлын төрөл	Тоо	Нэгжийн зардал	Нийт зардал
1	Цалин /дарга/	1	1,500,000	18,000,000
2	Цалин /гишүүд/	8	1000,000	96,000,000
3	Цалин/ нарийн бичгийн дарга/	1	900,000	10,800,000
4	ТУЗ-ийн ээлжит хурлын зардал	4	2,000,000	8,000,000
5	ТУЗ-ийн ээлжит бус хурлын зардал	6	1,500,000	9,000,000
6	ТУЗ-н бичиг хэрэг			10,000,000
7	ТУЗ-ын томилолт			50,000,000
Нийт дүн				201,800,000

Та бүхэн ТУЗ-ийн зардлын төсөвтэй танилцан саналаа өгнө үү.

Хувьцаа эзэмшигч Ганболд: Давуу эрхийн хувьцаагаа хэзээ гаргасан бэ.

Ч.Чинзориг: Компани давуу эрхийн хувьцаа гаргаагүй.

Хувьцаа эзэмшигч Ганболд: Нэмэлт хувьцаа гаргана гэж байна тэ, 20 хувьтай тэнцэх 5 тэрбумаасаа . Энэ жил гаргах уу

Ч.Чинзориг: Тийм, энэ жил гаргах учраас бид зарласан хувьцааны тоогоо дахин ээлжит бус хурал хуралдуулах шаардлагатай болох учраас энэ хуралд зарласан хувьцааны тоог нэмэгдүүлэх асуудлыг оруулсан байгаа.

Хувьцаа эзэмшигч Ганболд: Зээлийн гол үзүүлэлт нь машин юм байна. Ер нь машины зээлийн салбар ямархуу байна.

Ч.Чинзориг: Саяны Улаанбаатар хотын шийдвэртэй холбоотой машины эрэлт эрчимтэй нэмэгдсэн. Жилээс жилд хүн ам өсөж, хүмүүсийн орлого нэмэгдэж байгаатай холбоотой машины хэрэглээ нэмэгдэж байгаа. Мөн ковидын дараагаас дотоодын аялал жуучлал ихэссэнтэй холбоотой машины худалдан авалт нэмэгдсэн. Тогтвортой байгаа

Өөр асуух асуулт байна уу.

За асуух асуулт байхгүй байвал саналын хуудсаараа саналаа өгнө үү.

Тооллогын комиссын дарга М.Уянга: Тооллогын комиссын дүн гарч дууслаа.

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2024 оны 3 сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц Компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцаа буюу 1,507,838,708 ширхэг хувьцаанаас тус өдрийн хуралд 1,202,846,324 ширхэг энгийн хувьцаа эзэмшигчид ирсэн нь саналын эрх бүхий хувьцааны 79.77% болж ирц бүрдсэн байна. Энэ нь хурлын ирц Компанийн тухай хуулийн 69-р зүйлийн 69.1-д заасан болон Компанийн дүрэмд заасантай тус тус бүрэн нийцсэн.

1. Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99.9% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 79.76% саналаар зөвшөөрч баталсан.

2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99.9% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 79.76% саналаар зөвшөөрч баталсан.
3. Компанийн Нэмэлт хувьцаа гаргах талаар хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99.9% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 79.76% саналаар зөвшөөрч баталсан. Тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байх талаар тогтоосугай. ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99.9% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 79.76% саналаар зөвшөөрч баталсан.
4. Компанийн шинэчилсэн дүрмийн өөрчлөлтүүдийг хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99.9% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 79.76% саналаар зөвшөөрч баталсан.
5. Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн батлах талаар хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99.9% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 79.76% саналаар зөвшөөрч баталсан.
6. 2024 оны ТУЗ-ийн зардлын төсвийг хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99.9% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 79.76% саналаар зөвшөөрч баталсан.

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2024 оны 3 сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дээрх асуудлыг хэлэлцэж саналыг саналын хуудсаар авч баталгаажууллаа. Хуралд нийт арван есөн хувьцаа эзэмшигчдээс саналын хуудас ирсэн. Нэр бүхий хувьцаа эзэмшигчдийн арван долоон саналын хуудсыг хүчинтэйд тооцож хоёр саналын хуудсыг хүчингүйд тооцсон. Хуулбарыг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид бусад материалын хамт хүргүүлэхийг гүйцэтгэх захирал Ж.Ганхүлэгт үүрэг болгосугай.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:  Б.Бадамцэцэг/

Хурлын дарга:  /Ч.Чинзориг/

